



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/8/СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа

Утас: 70357955 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	Error! Bookmark not defined.
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Error! Bookmark not defined.
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	5
3.1. Ерөнхий зүйл.....	5
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	5
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	5
3.4. Материаллаг байдал	6
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	5
3.7. Шилэн дансны мэдээлэл	6
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	6
3.9. Аудитын илрүүлэлт.....	7
Залруулсан алдаа	6
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	7
Аудитын зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	Error! Bookmark not defined.
4. Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	9

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 79
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ЗДТГ-ЫН
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Н.БЯМБАЦЭЦЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Н.Бямбацэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 03/130 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа “excel” программ дээр гүйцэтгэжээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 10,370,965.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 103,709.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Төсвийн төлөвлөлт

Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны төсвийн зардлыг аймгийн ИТХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 15/03 дугаар тогтоолоор 7,513,546.6 мянган төгрөг, 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 752,056.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 8,265,603.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 10,344,583.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 26,382.5 мянган төгрөг, нийт 10,370,965.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 9,050,225.3 мянган төгрөгийг зарцуулж 1,320,740.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын шилэн дансны мэдээллийг Орхон аймаг засаг дарга цэсэд байршуулдаг бөгөөд тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7,380.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 31,940.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 22,770.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	7,380.0	2	7,380.0	-		
Албан шаардлага	1	31,940.0	1	31,940.0	-		
Зөвлөмж	3	22,770.0	3	22,770.0	-		
Нийт дүн	6	62,090.0	6	62,090.0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,559.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5,847.9 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 7,811.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,900.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 15,559.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 5,847.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 7,811.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.Үүнд:

1. Эйр транс ХХК-д 2020.02.07-ны өдөр 5,847,900 төгрөгийг 3 хүний БНСУ-ын тийзний үнэ төлсөн бөгөөд явсан эсэх нь тодорхойгүй, гадаад улсад томилолтоор ажиллаад ямар үр дүн гарсан талаар анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, тодорхойгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Аймгийн Засаг даргын 2020.02.13-ны өдрийн А/188 дугаар тушаалаар БНСУ-ын Сөүл хотноо 2020 оны 02 дугаар сарын 16-21-ны өдрийн хооронд зохион байгуулагдах "Удирдлагын хүний нөөцийн хөгжил" сургалтад оролцох Шуудан үйлчилгээний газрын дарга Ц.Алтаншагайд дэмжлэг үзүүлэх 2000.0 мянган төгрөгийг 2020.02.14-ны өдөр шилжүүлсэн боловч сургалтад явсан эсэх, сургалтаар ямар үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна. Мөн 2020.02.12-ны өдрийн 30 дугаарын төлбөрийн хүсэлтээр 2,005.0 мянган төгрөгийг Засаг даргын 2020.2.11-ны өдрийн А/82 дугаар захирамжаар БНСУ-д зохион байгуулагдах "Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн" сургалтад Хот тохижуулах газрын дарга Б.Оюунбаярт дэмжлэг үзүүлэхээр Олон улсын мэргэжлийн хөгжлийн институтын дансанд шилжүүлсэн боловч БНСУ-руу явсан сургалтын үр дүнгээр ямар ажил зохион байгуулагдсан нь анхан шатны баримтаар дэмжигдэхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Аймгийн Засаг даргын 2020.07.03-ны А/425 дугаар захирамжаар тогтвортой хот ба хүн амын нутагшилт суурьшилт хот суурин газрыг хөгжүүлэх сургалт зардалд 3,806.6 мянган төгрөгийг “Хот байгуулалт барилга захилагчийн алба” ОНӨҮГ-т шилжүүлсэн боловч сургалтад хамрагдаагүй баруун таван аймгийн аялалд явж төсвийн хөрөнгийг үр ашиггүй,

зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай

Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна. Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1,900.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын зарлагын гүйлгээний анхан шатны баримтын иж бүрэн байдлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын 2020.12.24-ны өдрийн А/788 дугаарын захирамжаар Барилгачин залуучуудын холбоонд 1,900.0 мянган төгрөг шилжүүлэхдээ гэрээнд заагдсан "Хашаандаа хаус" хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын гудамжуудад татсан инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтой өрхүүдийн судалгааг хийх, амины орон сууцны дулаан алдагдлыг бууруулах талаар зөвлөмж бэлтгэн хүргүүлэх ажлыг хэрхэн гүйцэтгэсэн талаар анхан шатны баримт хангалтгүй, судалгаа хийсэн үр дүн тодорхойгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- 1.2. Эрсдэл: Анхан шатны баримтын бүрдэл хангагдахгүй байх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Гэрээнд тусгагдсан ажил бүрэн хийгдэж, ямар үр дүн гарсныг анхан шатны баримтад бүрэн хавсаргаж байх.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 03/130 дугаарын албан бичгээр хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Т.БОЛОРМАА

ОРА-2021/8/СТА-ОНТС

7

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ОРА-2021/8/СТА-ОНТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардал		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эйр транс ХХК-д 2020.02.07-ны өдөр 5,847,900 төгрөгийг 3 хүний БНСУ-ын тийзний үнэ төлсөн бөгөөд явсан эсэх нь тодорхойгүй, гадаад улсад томилолтоор ажиллаад ямар үр дүн гарсан талаар анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, тодорхойгүй	5,847.9	Төлбөрийн акт	СТСХ-ийн дарга, нягтлан бодогч	Н.Бямбацэцэг Ч.Энхцэцэг
2	Аймгийн Засаг даргын 2020.02.13-ны өдрийн А/188 дугаар тушаалаар БНСУ-ын Сөүл хотноо 2020 оны 02 дугаар сарын 16-21-ны өдрийн хооронд зохион байгуулагдах "Удирдлагын хүний нөөцийн хөгжил" сургалтад оролцох Шуудан үйлчилгээний газрын дарга Ц.Алтаншагайд дэмжлэг үзүүлэх 2000.0 мянган төгрөгийг 2020.02.14-ны өдөр шилжүүлсэн боловч сургалтад явсан эсэх, сургалтаар ямар үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна. Мөн 2020.02.12-ны өдрийн 30 дугаарын төлбөрийн хүсэлтээр 2,005.0 мянган төгрөгийг Засаг даргын 2020.2.11-ны өдрийн А/82 дугаар захирамжаар БНСУ-д зохион байгуулагдах "Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн" сургалтад Хот тохижуулах газрын дарга Б.Оюунбаярт дэмжлэг үзүүлэхээр Олон улсын мэргэжлийн хөгжлийн институтын дансанд шилжүүлсэн боловч БНСУ-руу явсан сургалтын үр дүнгээр ямар ажил зохион байгуулагдсан нь анхан шатны баримтаар дэмжигдэхгүй	4,005.0	Албан шаардлага	СТСХ-ийн дарга, нягтлан бодогч	Н.Бямбацэцэг Ч.Энхцэцэг

Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	аймгийн аялалд явж төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан				
4	Аймгийн Засаг даргын 2020.12.24-ны өдрийн А/788 дугаарын захирамжаар Барилгачин залуучуудын Холбоонд 1,900.0 мянган төгрөг шилжүүлэхдээ гэрээнд заагдсан "Хашаандаа хаус" хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын гудамжуудад татсан инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтой өрхүүдийн судалгааг хийх, амины орон сууцны дулаан алдагдлыг бууруулах талаар зөвлөмж бэлтгэн хүргүүлэх ажлыг хэрхэн гүйцэтгэсэн талаар анхан шатны баримт хангалтгүй, судалгаа хийсэн үр дүн тодорхойгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.	1,900.0	Зөвлөмж	СТСХ-ийн дарга, нягтлан бодогч	Н.Бямбацэцэг Ч.Энхцэцэг
ДҮН		15,559.5			

АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛИЙГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

Т.БОЛОРМАА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 58/58 ОАА 2021/8/ СТА-ОНТС Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эйр транс ХХК-д 2020.02.07-ны өдөр 5,847,900 төгрөгийг 3 хүний БНСУ-ын тийзнэй үнэ төлсөн бөгөөд явсан эсэх нь тодорхойгүй, гадаад улсад томилолтоор ажиллаад ямар үр дүн гарсан талаар анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 100/100 ОАА-2021/ 8/074-0111 Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2020.02.13-ны өдрийн А/188 дугаар тушаалаар БНСУ-ын Сөүл хотноо 2020 оны 02 дугаар сарын 16-21-ны өдрийн хооронд зохион байгуулагдах "Удирдлагын хүний нөөцийн хөгжил" сургалтад оролцох Шуудан үйлчилгээний газрын дарга Ц.Алтаншагайд дэмжлэг үзүүлэх 2000.0 мянган төгрөгийг 2020.02.14-ны өдөр шилжүүлсэн боловч сургалтад явсан эсэх, сургалтаар ямар үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

- Мөн 2020.02.12-ны өдрийн 30 дугаарын төлбөрийн хүсэлтээр 2,005.0 мянган төгрөгийг Засаг даргын 2020.2.11-ны өдрийн А/82 дугаар захирамжаар БНСУ-д зохион байгуулагдах "Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн" сургалтад Хот тохижуулах газрын дарга Б.Оюунбаярт дэмжлэг үзүүлэхээр Олон улсын мэргэжлийн хөгжлийн институтын дансанд шилжүүлсэн боловч БНСУ-руу явсан сургалтын үр дүнгээр ямар ажил зохион байгуулагдсан нь анхан шатны баримтаар дэмжигдэхгүй байна.

Энэ нь 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан

шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн СТСХ-ийн дарга Н.Бямбацэцэг, засаг даргын төсөл хөтөлбөрийн зардлын нягтлан бодогч Ч.Энхцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР..........**Ц.НАРМАНДАХ**

АУДИТЫН
МЕНЕЖЕР..........**Б.ЭРДЭНЭ**

АУДИТОР..........**Т.БОЛОРМАА**



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 101/101 ОДМ-2021/2 /СТХ-ОНТС Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2020.07.03-ны А/425 дугаар захирамжаар тогтвортой хот ба хүн амын нутагшилт суурьшилт хот суурин газрыг хөгжүүлэх сургалт зардалд 3,806.6 мянган төгрөгийг "Хот байгуулалт барилга захиалагчийн алба" ОНӨҮГ-т шилжүүлсэн боловч сургалтад хамрагдаагүй баруун таван аймгийн аялалд явж төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн СТСХ-ийн дарга Н.Бямбацэцэг, засаг даргын төсөл хөтөлбөрийн зардлын нягтлан бодогч Ч.Энхцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН

МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Т.БОЛОРМАА